



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Г  
Зам, тээврийн салбарын аюулгүй ажиллагаа,  
тээвэрлэлтийн аюулгүй байдлыг өндөржүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Зам, тээврийн салбарын аюулгүй ажиллагаа, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг өндөржүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Зам, тээврийн салбарт төрийн хяналт зохицуулалт, төрийн үйлчилгээг хэрэгжүүлж буй харьяа агентлаг, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга, захирал нарт дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

1.1. Ачаа, зорчигч тээвэрлэгч, замын байгууллагуудын сахилга хариуцлага, дэг журмыг дээшлүүлэх, хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, тээвэрлэлтийн болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуюлж ажиллах;

1.2. Хариуцсан чиг үүрэг, хяналт зохицуулалт, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарт онцгой анхаарч, иргэд, байгууллагад хүнд суртал, чирэгдэл учруулахгүй үйлчлэх;

1.3. Аюулгүй ажиллагаа, тээврийн аюулгүй байдал, дотоод хяналтын асуудал хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг өндөржүүлж, хариуцлага алдсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч ажиллах;

1.4. Аюулгүй ажиллагаа, тээврийн аюулгүй байдлын талаар харьяа аж ахуйн нэгж, байгууллагаас мэдээлэл авах, нэгтгэх, хяналт тавих, тавьсан санал, хүсэлтийг судалж, шуурхай шийдвэрлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг агентлаг, байгууллагын дэргэд байгуулан ажиллуулах;

1.5. Харилцаа холбоо, удирдлага хяналтын техник хэрэгслийн найдвартай ажиллагааг ханган ажиллах замаар осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, осол зөрчил гаргуулахгүй байх тухай мэдээ, мэдээллийг иргэд, тээвэр эрхлэгчдэд тогтмол хүргэж ажиллах;

1.6. Цаг уур, орчны шинжилгээний газрын албан мэдээнээс үзэхэд 2019 оны 1 дүгээр сард олон жилийн дунджийн орчим, 2 дугаар сард олон жилийн дунджаас ахиу цас орж, хүйтрэх төлөвтэй байгаа тул тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг бүрэн хангах, шаардлагатай сэлбэг материалын нөөцийг бүрдүүлэхэд анхаарч ажиллах;

## 2. Иргэний нисэхийн чиглэлээр:

2.1. Иргэний нисэхийн салбар/нисэх онгоцны буудал, харьяа нэгж, албад, авиа компаниуд/-ын аюулгүй ажиллагаа, нислэгийн аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, салбарын хэмжээнд техник, тоног төхөөрөмжийн өвлүүлийн ашиглалтын бэлэн байдлыг хангах, агаарын хөлгийн засвар, үйлчилгээний чанарыг сайжруулж, салбарын осол, зөрчилгүй хэвийн үйл ажиллагааг ханган шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, түлшний нөөцийг бүрдүүлж ажиллах;

2.2. Агаарын тээврийн компаниудтай хамтран улс, орон нутгийн нислэгийн хуваарь чиглэлд зохицуулалт хийх замаар бэлэн байдлын үед ажиллах хуваарь батлах, хийсэн зохицуулалтын талаар олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах.

## 3. Автотээвэр, мөсөн замын тээврийн чиглэлээр:

3.1. Улс, хот хоорондын зорчигч, ачаа тээвэрлэх тээврийн хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангуулж, засвар үйлчилгээний чанарыг сайжруулж, сэлбэг хэрэгсэл болон шатахуун, тослох материалыг зохих хэмжээнд нь нөөцөлж, иргэдэд осол зөрчилгүй, сааталгүй, найдвартай, тав тухтай үйлчлэх нөхцөл бүрдүүлэх;

3.2. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зорчигчдод цаг агаарын төлөв, нөхцөл байдлын талаарх мэдээлэл, сурталчилгаа хүргэж, албан ёсны зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх ач холбогдлыг сурталчлан таниулах арга хэмжээ авах;

3.3. Тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллах, үүрэг, даалгавар биелүүлж ажиллаагүй тохиолдолд гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авах;

3.4. Нутаг дэвсгэртээ орших гол мөрөн, нуурын мөсөн замын тээвэрлэлт эхлэх, дуусах хугацаа, чиглэл, мөсний даацыг орон нутгийн цаг уур, орчны хяналт шинжилгээний байгууллагатай хамтран тогтоон, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд нь хяналт тавьж, иргэдийг зөвшөөрөгдөөгүй мөсөн замаар зорчих, тээвэр хийхээс урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлан танилцуулж ажиллах.

## 4. Авто замын чиглэлээр:

4.1. Цаг агаарын хүндрэлтэй үед улсын болон орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж, гүүрийн эвдрэл гарч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулах явдлаас урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгсэл саадгүй нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэх, зам, даваа хаагдсан үед улсын болон орон нутгийн чанартай авто замыг бэлэн байлгахад шаардагдах хөрөнгө, техник хэрэгсэл, хүн хүчийг байнгын бэлэн байлгаж, эдгээр авто зам цасанд хаагдаж, боогдсон тухай бүрд нь нээх арга хэмжээг орон нутгийн удирдлага, онцгой байдлын газартай хамтран шуурхай зохион байгуулж ажиллах;

4.2. Бүс нутаг хариуцсан хяналтын инженерүүдийг Бэлэн байдлын хугацаанд томилон ажиллуулах, даац, оврын хэмжээ хэтрүүлэн тээвэрлэлт эрхэлж буй үйл ажиллагааг холбогдох газруудтай хамтран зогсоох арга хэмжээ авч ажиллах.

5. Төмөр замын тээврийн чиглэлээр:

5.1. Төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй байдлыг бүрэн хангаж, зүтгүүр, ачаа, зорчигчийн вагон болон бусад төмөр замаар явагч машин механизмын их, дунд, засвар, техникийн үзлэг, үйлчилгээний чанарыг сайжруулж, ашиглалтад шаардлагатай сэлбэг хэрэгсэл, түлшний нөөцийг бүрдүүлж бэлэн байдлыг хангаж ажиллах;

5.2. Төмөр замын суурь бүтэц, зам, гүүр, хоолойн байгууламжийн их засвар, үзлэг, үйлчилгээ, дохиолол холбооны байгууламжийн тохируулга, үйлчилгээний чанарыг сайжруулж, цаг агаарын хүндрэлтэй үед хөдөлгөөнд саад учрах эрсдэл, осол, гологдол, зөрчлөөс урьдчилан сэргийдэж ажиллах;

5.3. Цаг агаар хүндэрч, тээврийн хэрэгсэл аюулгүй зорчих боломжгүй болсон нөхцөлд “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай хамтран зорчигчид дамжин суух боломж бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

1. Тушаалаар өгөгдсөн үүргийн хэрэгжилтийн явцыг тогтмол танилцуулж, шаардлагатай мэдээллийг шуурхай дамжуулж ажиллахыг яамны холбогдох бүтцийн нэгж, харьяа агентлаг, төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга, захирал наарт үүрэг болгосугай.

2. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтэд үнэлэлт өгэн, сайдын шуурхай хуралд мэдээлж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар/М.Энхболд/-т даалгасугай.

